



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/204

Улаанбаатар хот

**Хүний эрхийн төлөө хамтдаа”
нээлттэй өдрийг дүүрэгт зохион байгуулах
Ажлын хэсгийг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүрэгт “Хүний эрхийн төлөө хамтдаа” нээлттэй өдрийн арга хэмжээг 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулсугай.

2.Нээлттэй өдрийн арга хэмжээг зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар, арга хэмжээний хөтөлбөрийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.“Хүний эрхийн өдөр”-ийн нээлттэй арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдах сургалт, хэлэлцүүлгийн танхимын техник хэрэгслийн бэлтгэл, бэлэн байдлыг хангаж ажиллахыг Соёлын ордон (Б.Алтанцоож)-д, “Үе тэнгийнхний дарамт, хүчирхийлэл, түүний хор уршиг, урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт сургалтад Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдыг идэвхтэй хамруулахыг Хангай сургууль (Э.Соёмбобат)-д, “Хүний эрхийн төлөө хамтдаа” нээлттэй өдрийн хүрээнд зохион байгуулагдах арга хэмжээг иргэдэд сурталчлан, таниулах ажлыг зохион байгуулахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Б.Отгонжаргал), хороодын Засаг дарга (Н.Нямзав, Б.Батзориг) нарт тус тус үүрэг болгосугай.

4.Арга хэмжээнд зарцуулагдах 749,000 (Долоон зуун дөчин есөн мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.


5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, аж ахуйн нэгж байгууллагуудыг нэгдсэн удирдлагаар ханган, арга хэмжээнд идэвхтэй оролцуулахыг Ажлын хэсэг (Л.Санжийжамц)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 2 дугаар сарын 7 ны өдрийн 1 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



“ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА” НЭЭЛТТЭЙ
ӨДРИЙН АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн

ахлагч:

Л.Санжийжамц

Гишүүд:

Б.Отгонжаргал

Б.Алтанцоож

Э.Соёмбобат

Н.Нямзав

Б.Батзориг

Нарийн бичиг:

Б.Одбаяр

Засаг даргын Тамгын газрын дарга

Төрийн захиргааны удирдлагын

хэлтсийн дарга

Соёлын ордны захирал

Хангай сургуулийн захирал

1 дүгээр хорооны Засаг дарга

2 дугаар хорооны Засаг дарга

Төрийн захиргааны, удирдлагын

хэлтсийн мэргэжилтэн




Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 1204 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

“ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА” НЭЭЛТТЭЙ ӨДРИЙГ
НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРЭГТ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ

№	Материалын нэрс	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Тараах материал	ширхэг	100	3,750	375,000
2	Ус	ширхэг	50	1,200	60,000
3	Печень	ширхэг	3	18,000	54,000
4	Нэг удаагийн аяга	боодол	2	10,000	20,000
5	Сургалтын танхимын түрээс	цаг	6	40,000	240,000
НИЙТ					749,000

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 10 дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт



“ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА” НЭЭЛТТЭЙ
ӨДРИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Цаг	Зохион байгуулах ажил	Оролцогч	Хариуцах албан тушаалтан	Зохион байгуулах газар
1	09:00 09:30	Дүүргийн удирдлагуудтай уулзалт хийх	Дүүргийн ИТХ-ын дарга, Засаг дарга, Засаг даргын орлогч, Дүүргийн менежер, ЗДТГ-ын дарга, ААНБ-уудын удирдлага	С.Дондов Комиссын гишүүн, Ажлын хэсэг, Б.Ардак ИНЗ-ийн гишүүн ЗДТГ-Б.Одбаяр, Н.Батболд	ЗДТГ-ын Хурлын танхим
2	09:40 17:00	Дүүргийн ЗДТГ, цэцэрлэгт хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилттэй танилцах.	Л.Санжийжамц, С.Отгонтуяа	С.Дондов Комиссын гишүүн, Д.Намжилсүрэн Референт, Б.Ардак ИНЗ-ийн гишүүн	ЗДТГ, 207 дугаар цэцэрлэг
3	09:40 11:00	“Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр II”- төслийн хэлэлцүүлэг	Дүүргийн ИТХ-ын дарга, Засаг дарга, Засаг даргын орлогч, Дүүргийн менежер, ЗДТГ-ын дарга, ААНБ-уудын удирдлага	С.Тунгалагтамир Хэлтсийн дарга, Д.Ёндонжамц Хэлтсийн дарга, М.Одмаа Мэргэжилтэн, ЗДТГ-Б.Одбаяр, Н.Батболд	ЗДТГ-ын Хурлын танхим
4	09:30 18:00	Иргэдээс өргөдөл, гомдол хүлээн авч, хууль зүйн зөвлөгөө өгөх	Иргэд (нээлттэй)	Д.Ганчимэг Ахлах мэргэжилтэн, ЗДТГ-Н.Батцэнгэл	ЗДТГ-ын Түүхийн танхим
5	10:00 13:00	“Бидний эрх, бидний ирээдүй, яг одоо” хүний эрхийн сургалт хийх	ААНБ-уудын ажилтан, албан хаагчид	Д.Ёндонжамц Хэлтсийн дарга, И.Мөнхбаяр Референт, М.Одмаа Мэргэжилтэн, ЗДТГ-Б.Одбаяр, Н.Өлзийцэцэг, Н.Батболд	Соёлын ордон
13:00-14:00		Үдийн завсарлага			
6	14:00 16:00	Хүний эрхийн талаарх кино хэлэлцүүлэг өрнүүлэх	ЕБС-ийн ахлах ангийн сурагчид, нийгмийн ажилтан	Б.Наранжаргал Мэргэжилтэн, М.Одмаа Мэргэжилтэн, ЗДТГ-Б.Одбаяр, Б.Оюунбаатар	Соёлын ордон

7	14:00 15:30	“Үе тэнгийнхний дарамт, хүчирхийлэл, түүний хор уршиг, урьдчилан сэргийлэх арга зам” сургалт	ЕБС-ийн ахлах ангийн сурагчид, нийгмийн ажилтан	И.Мөнхбаяр Референт, Б.Ардак ИНЗ-ийн гишүүн ЗДТГ-Б.Одбаяр, Н.Батболд, Б.Оюунбаатар	
8	16:30 17:20	“Хүний эрхийн төлөө хамтдаа” нээлттэй өдөр арга хэмжээний үр дүнг танилцуулах	Дүүргийн ИТХ-ын дарга, Засаг дарга, Засаг даргын орлогч, Дүүргийн менежер, ЗДТГ-ын дарга, ААНБ-уудын удирдлага	С.Дондов Комиссын гишүүн, Д.Ёндонжамц Хэлтсийн дарга, С.Тунгалагтамир Хэлтсийн дарга, Д.Намжилсүрэн Референт	ЗДТГ-ын Хурлын танхим